



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

┌ Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Зөвлөл байгуулах тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 51 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн бүрэлдэхүүний тоог 7 байхаар тогтоож хавсралтаар баталсугай.

2. Хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 10 дугаар сарын 31 -ний
өдрийн 46 тогтоолын хавсралт

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэрс	Албан тушаал	Нэр дэвшсэн нам, эвсэлийн нэр
1	Ч.Бат-Оргил	Хурлын дарга	Монгол ардын нам
2	Ч.Базарзаяа	Төлөөлөгч	Монгол ардын нам
3	Б.Алтантуяа	Төлөөлөгч	Монгол ардын нам
4	А.Отгон-Эрдэнэ	Төлөөлөгч	Монгол ардын нам
5	С.Сайнбаяр	Төлөөлөгч	Монгол ардын нам
6	Д.Ганбадрах	Төлөөлөгч	Монгол ардын нам
7	П.Мөнхбаатар	Төлөөлөгч	Ардчилсан нам